



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГАА-2022/92/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Алтай хот 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор: Х.Түвшинбаяр Утас: 70483413 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг Утас: 70484055 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn Аудитор Б.Нямдорж Утас: 99998436 Цахим хаяг: bnyamdorj5@gmail.com</p>	
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	1
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	2
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

9018301, Говь-Алтай аймаг,
Есөнбулаг сум, 7-р баг, Жинст 0
Утас: 70-48-34-13. Факс: (976) 70-48-34-13,
E-mail: govialtai@audit.gov.mn

2022.02.28 № 144

танай _____ -ны № _____ -т

Г Зөрчилгүй дүгнэлт Г

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.ТҮВШИНБАЯР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	124,204,946.11	102,623,948.84
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	2,447,643.08	(0.00)
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	2,447,643.08	-
31110	Төгрөг	2,447,643.08	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	(0.00)
31210	Төгрөг	-	(0.00)
31211	Төрийн сангийн харилцах	-	(0.00)
33	АВЛАГА	3,294,092.52	1,244,592.52
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	935,533.52	935,533.52
33101	Цалингийн авлага	821,663.00	821,663.00
33102	НДШ-ийн авлага	113,870.52	113,870.52
33500	Бусад авлага	2,358,559.00	309,059.00
33510	Байгууллагаас авах авлага	2,125,100.00	75,600.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	233,459.00	233,459.00
35	БАРАА МАТЕРИАЛ	118,463,210.51	101,379,356.32
35100	Түүхий эд материал	130,000.00	237,960.00
35130	Эм боох материал	130,000.00	237,960.00
35400	Хангамжийн материал	118,333,210.51	101,141,396.32
35420	Аж ахуйн материал	95,558,806.95	84,919,224.44
35440	Түлш, шатах тослох материал	1,904,512.56	1,754,337.56
35450	Барилгын засварын материал	13,743,023.00	5,940,000.00
35460	Хүнсний материал	-	0.00
35470	Бусад хангамжийн материал	7,126,868.00	8,527,834.32
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	1,049,261,221.07	1,121,216,337.92
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,049,261,221.07	1,121,216,337.92
39200	Биет хөрөнгө	958,742,887.95	1,030,479,254.88
39201	Барилга, байгууламж, орон сууц	972,371,672.59	972,371,672.59
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(125,090,088.24)	(183,605,497.08)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	13,040,000.00	13,040,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(13,040,000.00)	(13,040,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	252,951,413.10	201,644,506.60
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(203,053,277.68)	(57,767,013.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	102,283,614.60	84,672,674.56
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(72,807,148.58)	(21,567,214.81)
39214	Бусад үндсэн хөрөнгө	15,155,207.52	10,815,480.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(8,856,725.36)	(1,873,573.60)
39217	Номын фонд	25,788,220.00	25,788,220.00
39300	Биет бус хөрөнгө	90,518,333.12	90,737,083.04
39301	Програм хангамж	1,090,000.00	1,090,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(571,666.88)	(352,916.96)
39303	Бусад биет бус хөрөнгө	90,000,000.00	90,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	1,173,466,167.18	1,223,840,286.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	1,173,466,167.18	1,223,840,286.76
51	Засгийн газрын хувь оролцоо	1,173,466,167.18	1,223,840,286.76
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	433,415,254.34	433,415,254.34
51200	Хуримтлагдсан үр дүн	(175,208,131.17)	(114,962,184.07)
51210	Өмнөх үеийн үр дүн	(175,208,131.17)	(165,336,303.65)
51220	Тайлант үеийн үр дүн	-	50,374,119.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	915,259,044.01	905,387,216.49
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	1,173,466,167.18	1,223,840,286.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,072,381,075.68	1,201,016,850.37
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	48,122,732.68	160,229,623.37
1200	Нийтлэг татварын бус орлого	48,122,732.68	160,229,623.37
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	48,122,732.68	146,307,266.22
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	2,449,643.08	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	45,673,089.60	146,307,266.22
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	11,892,191.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	2,030,165.49
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,024,258,343.00	1,040,787,227.00
1310	Улсын төсвөөс	953,414,585.00	938,644,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	953,414,585.00	938,644,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	33,593,758.00	4,549,327.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	31,456,758.00	4,549,327.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,137,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,250,000.00	97,593,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,250,000.00	97,593,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	1,107,895,971.57	1,148,444,118.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,107,895,971.57	1,148,444,118.29
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,306,653.19	1,091,711,031.22
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	772,665,765.65	776,010,140.28
210101	Үндсэн цалин	632,456,885.37	643,466,319.59
210104	Урамшуулал	57,422,851.75	54,411,646.90
210105	Гэрээт ажлын цалин	82,786,028.53	78,132,173.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,927,816.66	103,718,360.92
210201	Тэтгэврийн даатгал	73,287,327.29	74,269,379.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,920,000.00	7,590,670.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,449,307.49	6,005,292.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,570,089.36	1,427,624.61
210205	Эрүүл мэндийн даатгал	15,701,092.52	14,425,393.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,187,796.31	75,328,977.21
210301	Гэрэл, цахилгаан	3,590,996.31	3,733,395.71
210302	Түлш, халаалт	25,996,800.00	70,995,581.50
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,366,500.00	27,023,611.00
210401	Бичиг хэрэг	-	1,083,300.00
210402	Тээвэр, шатахуун	2,132,000.00	1,857,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,000.00	900,000.00
210404	Ном, хэвлэл	7,800.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	296,000.00	80,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,110,700.00	5,722,400.00
210408	Бараа материал актласны зардал	-	17,305,911.00
2105	Нормативт зардал	9,159,254.86	11,932,336.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	860,900.00	1,785,000.00
210502	Хоол, хүнс	8,298,354.86	8,887,336.52
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,260,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	517,100.00	3,877,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	320,000.00
210604	Урсгал засвар	517,100.00	3,557,000.00
2107	Томилолт, зочны зардал	618,000.00	1,446,000.00
210702	Дотоод албан томилолт	618,000.00	1,446,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,599,115.00	3,093,343.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,803,115.00	3,093,343.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,265,304.71	89,281,262.21
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	275,000.00	4,403,100.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	86,990,304.71	84,878,162.21
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,589,318.38	56,733,087.07
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,438,691.19	18,863,797.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,438,691.19	18,857,797.79
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,080,362.89	11,576,242.22
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,080,362.89	11,576,242.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,070,264.30	26,293,047.06
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,441,035.30	17,126,746.06
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	29,229,258.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,399,971.00	9,166,301.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,198,612.50
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(35,514,895.89)	52,572,732.08
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	2,198,612.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	2,198,612.50
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,198,612.50
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	(35,514,895.89)	50,374,119.58

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	НИЙТ ДҮН
1	ҮЛДЭГ ДЭЛ	-	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
8	ҮЛДЭГ ДЭЛ	433,415,254.34	915,259,044.01	(175,208,131.17)	-	1,173,466,167.18
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	9,871,827.52	-	9,871,827.52
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	433,415,254.34	915,259,044.01	(165,336,303.65)	-	1,183,337,994.70
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(9,871,827.52)	-	-	(9,871,827.52)
12	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-	-	-	-	-
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
15	Тайлант үеийн үр дүн	-	-	50,374,119.58	-	50,374,119.58
16	ҮЛДЭГ ДЭЛ	433,415,254.34	905,387,216.49	(114,962,184.07)	-	1,223,840,286.76

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх жилийн дүн	Тайлант жилийн дүн
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,027,980,986.08	1,042,836,727.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,447,643.08	-
1200	Нийтлэг татварын бус орлого	2,447,643.08	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,447,643.08	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	2,447,643.08	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025,533,343.00	1,042,836,727.00
1310	Улсын төсвөөс	953,414,585.00	938,644,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	953,414,585.00	938,644,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	34,868,758.00	6,598,827.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	-	2,049,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	32,731,758.00	4,549,327.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,137,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	37,250,000.00	97,593,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	37,250,000.00	97,593,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	1,025,533,343.00	1,045,284,370.08
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,025,533,343.00	1,045,284,370.08
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	926,944,024.82	988,551,282.81
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	772,942,494.65	776,010,140.28
210101	Үндсэн цалин	632,733,614.37	643,466,319.59
210104	Урамшуулал	57,422,851.75	54,411,646.90
210105	Гэрээт ажлын цалин	82,786,028.53	78,132,173.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,927,816.66	103,718,360.92
210201	Тэтгэврийн даатгал	73,146,327.29	74,269,379.94
210202	Тэтгэмжийн даатгал	1,920,000.00	7,590,670.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,486,907.49	6,005,292.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,579,489.36	1,427,624.61
210205	Эрүүл мэндийн даатгал	15,795,092.52	14,425,393.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,811,308.81	75,178,802.21
210301	Гэрэл, цахилгаан	3,590,996.31	3,733,395.71
210302	Түлш, халаалт	26,620,312.50	70,845,406.50
210303	Цэвэр, бохир ус	600,000.00	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,452,500.00	5,739,827.00
210401	Бичиг хэрэг	900,000.00	1,598,827.00
210402	Тээвэр, шатахуун	1,980,000.00	1,611,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820,000.00	900,000.00
210404	Ном, хэвлэл	100,000.00	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	448,000.00	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,204,500.00	1,160,000.00
2105	Нормативт зардал	7,984,389.70	10,842,336.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	480,000.00	1,655,000.00
210502	Хоол, хүнс	7,264,389.70	8,887,336.32
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	240,000.00	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,280,000.00	7,070,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,233,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,280,000.00	1,280,000.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,557,000.00
2107	Томиллолт, зочны зардал	618,000.00	1,452,000.00
210702	Дотоод албан томиллолт	618,000.00	1,452,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,599,115.00	3,093,343.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,803,115.00	3,093,343.08
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	576,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,328,400.00	5,446,073.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	2,328,400.00	5,446,073.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	98,589,318.18	56,733,087.27
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,438,691.19	18,863,797.79
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,438,691.19	18,857,797.79
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	6,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,080,362.89	11,576,242.22
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,080,362.89	11,576,242.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	45,070,264.10	26,293,047.26
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	9,441,035.10	17,126,746.26
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг	29,229,258.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,399,971.00	9,166,301.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	2,447,643.08	(2,447,643.08)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	-	-
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	-	-
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)	2,447,643.08	(2,447,643.08)
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	2,447,643.08
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	2,447,643.08	-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		2,447,643.08
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,036,237,900.0	1,038,685,543.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,036,237,900.0	1,038,685,543.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,840,800.0	981,958,455.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	782,766,500.0	776,010,140.28
210101	Үндсэн цалин	648,443,400.0	643,466,319.59
210104	Урамшуулал	54,680,100.0	54,411,646.90
210105	Гэрээт ажлын хөлс	79,643,000.0	78,132,173.79
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,673,900.0	103,718,360.92
210201	Тэтгэврийн даатгал	76,676,800.0	74,269,379.94
210202	Тэтгэмжийн даатгал	7,478,200.0	7,590,670.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,605,200.0	6,005,292.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,565,000.0	1,427,624.61
210205	Эрүүл мэндийн даатгал	15,348,700.0	14,425,393.69
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,036,000.0	75,178,802.21
210301	Гэрэл, цахилгаан	6,000,000.0	3,733,395.71
210302	Түлш, халаалт	87,436,000.0	70,845,406.50
210303	Цэвэр, бохир ус	600,000.0	600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,091,000.0	4,091,000.00
210401	Бичиг хэрэг	910,000.0	910,000.00
210402	Тээвэр, шатахуун	651,000.0	651,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	900,000.0	900,000.00
210404	Ном, хэвлэл	150,000.0	150,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	320,000.0	320,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,160,000.0	1,160,000.00
2105	Нормативт зардал	11,106,000.0	10,842,336.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,655,000.0	1,655,000.00
210502	Хоол, хүнс	9,151,000.0	8,887,336.32
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300,000.0	300,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,071,000.0	7,070,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,233,400.0	2,233,400.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,280,000.0	1,280,000.00
210604	Урсгал засвар	3,557,600.0	3,557,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,300,000.0	898,000.00
210702	Дотоод албан томилолт	1,300,000.0	898,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	740,000.0	3,093,343.08
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	740,000.0	3,093,343.08
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,056,400.0	1,056,073.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,056,400.0	1,056,073.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	26,397,100.00	56,727,087.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,397,100.0	26,293,047.26
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	9,166,600.0	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,230,500.0	17,126,746.26
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	9,166,301.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,598,827.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,598,827.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,592,827.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,648,827.00
210401	Бичиг хэрэг	688,827.00
210402	Тээвэр, шатахуун	960,000.00
2107	Томилолт, зочны зардал	554,000.00
210702	Дотоод албан томилолт	554,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,390,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,390,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,598,827.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,598,827.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,598,827.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Шилэн баланс аудит” ХХК-ний Говь-Алтай салбарын аудитор Б.Нямдорж гүйцэтгэж, хяналтыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 02 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд суралцагчдын бие даан суралцах үйлийг дэмжин хоцрогдолгүй сургах, хөгжил төлөвшил, эрүүл аж төрөх хэв маяг, зөв дадалд суралцах чадвар эзэмшүүлэхэд эцэг эх, асран хамгаалагчдын оролцоо хамтын ажиллагааг өргөжүүлж,

хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлж, хосолсон сургалтын орчин бүрдүүлэн ажиллах зорилго тавьсан. Улмаар зорилгоо биелүүлэхэд чиглэсэн 14 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй. Монгол Улсын Засгийн газраас 43 дугаар тогтоолоор бүх шатны төсөв захирагч нарт төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажиллахыг даалгажээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт хариуцсан ажилтан тусгай төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж илэрсэн зөрчил дутагдлыг арилгах чиглэл өгч тайлагнан ажилладаг. Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардал 1,107.8 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22,1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 17.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны нийт зардал 1,148.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг гүйцэтгэлийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18.3 сая төгрөгөөр тооцсон.

Аудитын эрсдэл бага гэж үзэж тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг АДБОУС 2320-н 13-д заасны дагуу аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.9 хувиар буюу 48.3 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь бараа материал, үндсэн хөрөнгө, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 118.5 сая төгрөгөөс 17.1 сая төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал, барилгын засварын материал буурсантай холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 69.1 сая төгрөгийн, үнэ төлбөргүйгээр 3.4 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 72.3 сая төгрөгийн материалыг зарцуулж, 17.3 сая төгрөгийн бараа материалыг акталж устгаж, бараа материалын үлдэгдэл 101.4 сая төгрөг байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,472.7 сая төгрөгөөс 73.3 сая төгрөгөөр буурсан 2.2 сая төгрөгийн хөрөнгө авч, 11.9 сая төгрөгийн хөрөнгө хандиваар авч, ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож 144,9 сая төгрөгөөр нэмэгдсэн. Аймгийн ИТХ-ын тогтоолоор 84.5 сая төгрөгийн тавилга, машин тоног төхөөрөмжийг данс бүртгэлээс хасаж ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоохоор 147.9 сая төгрөгөөр бууруулж 1,399.4 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,222.9 сая төгрөг болж 49.4 сая төгрөгөөр өссөн нь хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү, тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ. Орлого өмнөх оноос 0.8 хувиар буюу 127.7 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгө, орлого өссөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 1.2 сая төгрөгийн авлага бууруулж бичилт хийснийг залруулж, тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 115,8 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,200.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 164.4 сая төгрөгөөр бууруулж, 1,036.2 сая төгрөгөөр баталжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 1,036.2 сая төгрөгийн төсөв баталснаас 938.6 сая төгрөгийг улсын төсвөөс 97.6 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл 2.4 сая төгрөг, улсын төсвөөс 938.6 сая төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 97.6 сая төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 6.6 сая төгрөг нийт 1,045.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд

1,014.8 сая төгрөгийг зарцуулж 11.6 сая төгрөгийг улсын төсөвт, 18.8 сая төгрөгийн орон нутгийн төсөвт тус тус буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,014.8 сая төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 6.8 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 3.9 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 18.9 сая төгрөгөөр, нормативд зардлыг 0.3 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 0.4 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийг 0.1 сая төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар 6.6 сая төгрөгийн гүйлгээ хийгдэн, 1.6 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардал, 0.6 сая төгрөгийг дотоод албан томилолт, 4.4 сая бараа үйлчилгээний бусад зардалд тус тус зарцуулсан байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 2 мэдээлэл, мэдгэхээгүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. 2021 оны 1,090.0 сая төгрөгийн 24 мэдээллийг ил тод байршуулахаас 43.2 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,035.3 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", "6.4.4.таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", "6.4.5.цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" гэсэн холбогдох заалттай нийцээгүй байна гэж байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 0.4 сая төгрөгийн төлбөрийн акт, 14.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгснөөс 1.2 сая төгрөгийн авлага барагдуулах тодорхой ажил зохион байгуулаагүй, Шилэн дансны хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн жилийн аудитаар

Дараа жилийн аудитаар:

- Шилэн дансны мэдээллийг бэлтгэх хугацаандаа үнэн зөв байршуулсан эсэх,
- Авлагыг барагдуулсан байдал бичилт харах, ажил зохион байгуулах, баталгаажуулах.
- И-баримтын бүрдэл хангалтгүй төрийн сангаар гүйлгээ хийсэн
- Цалин хөлс нэмэгдэл урамшуулал тооцох
- Орон нутгийн өмчийн газарт хүргүүлж байгаа актлах хөрөнгийн судалгааг хянах
- Төсвийн хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.9 төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийн алдааг залруулж, 0.2 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад өмнөх үеийн үр дүн рүү авлага бууруулсан 1.2 сая төгрөг, тооллогоор тоологдоогүй байсан 0.2 сая хөрөнгийн алдааг залруулсан.

Үнэ төлбөргүй ирсэн 0.9 сая төгрөгийн бараа материалыг орлогод авч залрууллаа.

4.2 Төлбөрийн акт

Ажилтанд амралт цалинг давхардуулан олгосон 0.2 сая төгрөгийг илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Хөдөлмөрийн тухай хуулийн 49.1-т "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хөдөлмөрийн үр дүнд тохируулан олгоно", Төрийн албаны тухай хуулийн 57.1-т "Төрийн албан хаагчид хууль болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хэрэгжүүлсний төлөө төрөөс цалин хөлс олгоно." -д заалттай нийцэхгүй, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

Цалингийн зардлаас гарсан 0.07 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаад тайланд тусгаагүй нөхөн тайлан гаргах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 04 дүгээр сарын 26- ний өдрийн А/99 дугаар тушаал, 2.1. Ажил олгогч нь тайланг хуулиар тогтоосон хугацаанд энэ журмын 2.2-т заасан шаардлагад нийцүүлэн гаргаж, 2.4-т заасан хэлбэрээр харьяалах Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ"-д заалттай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Урьд оны авлага 1.2 сая төгрөгийг өмнөх үеийн үр дүн рүү тохируулах бичилт хийж хаасан, авлага барагдуулах тал дээр тодорхой ажил зохион байгуулаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах," 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;"-д заалттай нийцэхгүй оршин байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10 -аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлө хуваарилах" гэж заасныг зөрчсөн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Өмнөх оны аудитаар илэрсэн зөрчлийг давтаж, тушаал шийдвэргүй үр дүнгийн урамшуулал, амралт цалинг давхардуулан олгосон нь Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" заасантай нийцэж байгаа тул нягтлан бодогчид сахилгын хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

Татварын тодорхойлолтоор 0.085 сая төгрөгийн илүү, төлөлт татварын цахим системд бүртгэлтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1-т "Аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 14.4.3-т "Бүх өр төлбөр" гэж заасныг зөрчсөн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Орон нутгийн өмчийн газар нь тус сургуулиас ирүүлсэн 2021 оны актлах хөрөнгийн жагсаалтын мөнгөн дүнг давтан шалгаж, хөрөнгийн бүртгэлтэй тулгаагүйн улмаас 0.05 сая төгрөгийн хөрөнгийг 54.8 сая төгрөгийн дүнтэйгээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол гаргуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйл, 77.2.1 Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй,

нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтийг хангуулах 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс 146 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 2 мэдээлэл, мэдээлэлгүй 2 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. 2021 оны 1,090.0 сая төгрөгийн 24 мэдээллийг ил тод байршуулахаас 43.2 сая төгрөгийн 1 мэдээллийг ил тод байршуулаагүй, 1,035.3 сая төгрөгийн 19 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.8-т “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтыг мөрдөн ажиллах

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Дэлгэр сумын Ерөнхий боловсролын сургууль	12	3.9	3	2.4	1	0.2	7	1.3	1	
	Дүн	12	3.9	3	2.4	1	0.2	7	1.3	1	